

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМЫН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ,  
САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2020 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2020.06.18

Лүн

Тус сумын Засаг дарга болон түүний Тамгын газарт 2020 оны эхний хагас жилийн байдлаар 115 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн байна. Сумын Засаг даргад 15 өргөдөл, Тамгын газарт 100 өргөдөл бичгээр ирснийг хүлээн авч холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариуг бичгээр болон утсаар гарган мэдэгдэж, хүргүүлэн ажиллаж байна.

Нийт 113 өргөдөл, гомдлыг 15 хоногийн хугацаанд нь, 1 өргөдлийг хугацаа хоцроож 100 хувь шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.

Ирсэн өргөдөл, гомдлыг ангилбал:

1. Иргэний бүртгэлтэй холбоотой – 89
2. Буцалтгүй тусламж, эмчилгээний зардал, тэтгэмж хүссэн – 12
3. Газрын асуудалтай холбоотой – 3
4. Ажлын байртай холбоотой – 2
5. Чөлөө хүссэн – 1
6. Бусад – 8

Газрын асуудлаар хандсан 3 өргөдлийг судалж 2 иргэний газрын захирамж гаргуулах, 1 иргэний өвөлжөөний газартай холбоотой хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн. Ажлын байртай холбоотой 2 өргөдлийг судалж, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх 2 албан хаагчийг ажлаас чөлөөлсөн. Эмчилгээний зардал, буцалтгүй тусламж, тэтгэмж хүссэн 12 өргөдлийг судлан үүнээс 7 өргөдлийн дагуу албан хаагчдад 1.400.000 төгрөгийн тэтгэмж олгож, 5 өргөдлийн дагуу иргэдэд 1.550.000 төгрөгийг олгов. Чөлөө хүссэн 1 өргөдлийг судлан хүүхэд асрах чөлөөг 1 жилээр сунгасан. Бусад асуудлаар хандсан 7 өргөдлийг судлан жирэмсний амралт олгож, дэмжлэг хүссэн тодорхойлолт, өөрийн эзэмшлийн газар худаг гаргах хүсэлтийг холбогдох газарт нь уламжилсан тодорхойлолтуудыг гарган шийдвэрлэсэн. 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.

Иргэний шилжилт хөдөлгөөн, улсын бүртгэлтэй холбоотой 89 өргөдөл, гомдол ирснийг 100 хувь шийдвэрлэсэн байна.

Иргэний шилжилт хөдөлгөөн, улсын бүртгэлтэй холбоотой 89 өргөдлийг ангилбал:

- Төрсний бүртгэл – 4
- Цахим үнэмлэх шинэ, сунгалт – 27
- Цахим үнэмлэх олголт – 30
- Шилжилт хөдөлгөөн – 28

Цахим сүлжээгээр, утсаар, амаар гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлт байхгүй болно.

ТАЙЛАН ХЯНАСАН:


ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

В.ГАНТУЯА

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Д.СУВД-ЭРДЭНЭ





Баянтал сумын 2020 оны эхний хагас жилийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлтийн байдал

20.06.18

№	Тайлан ирүүлсэн сум	Нийт ирсэн өргөдөл, санал, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт /хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
	Баянтал сумын ЗДТГ	115	114	0	1	1	99,13%

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, санал, гомдол, хүсэлт	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр /www.bayantal.gs.gov.mn/	Утсаар хандсан /11-11/	Биечлэн уулзсан /амаар/	Бусад /иргэдтэй ажиллах, нээлттэй өдөрлөгөөр/
1	Баянтал сумын ЗДТГ	115	115	—	—	—	—

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал өргөдөл, гомдол	Нийт тоо	Эзлэх хувь
1	Баянтал сумын ЗДТГ	1. Иргэний бүртгэл шилжилт хөдөлгөөнтэй холбоотой	89	77,39%
		2. Буцалтгүй тусламж, эмчилгээний зардал, тэтгэмж хүссэн	12	10,43%
		3. Бусад асуудлаар хандсан	8	6,96%
		4. Газрын асуудалтай холбоотой	3	2,61%
		5. Ажлын байртай холбоотой	2	1,74%
		6. Чөлөө хүссэн	1	0,87%

Тайлан гаргасан:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ 

Д.СУВД-ЭРДЭНЭ